



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2005 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орны их сургуульд Засгийн газрын тэтгэлгээр хүн суралцуулах асуудлыг зохицуулах зөвлөл"-ийн 2005 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ нь:

1. Гарди овогтой Бадрууныг Стэнфордын Их сургуульд сэтгэл судлалын чиглэлээр, Уранбаатар овогтой Чинзоригийг АНУ-ын Texas Wesleyan Их сургуульд хууль, зүйн чиглэлээр, Жамбалдорж овогтой Маргадыг АНУ-ын Вирджиниа мужийн Жорж Мэйсон Их сургуульд улс төр, олон улсын харилцааны чиглэлээр, Ням-Осор овогтой Болормааг Англи улсын Лондонгийн Эдийн засаг, улс төрийн шинжлэх ухааны сургуульд олон улсын харилцааны чиглэлээр, Минжүүрдорж овогтой Лхагвамандахыг БНХАУ-ын Хэбэйн Их сургуульд олон улсын худалдааны чиглэлээр, Сюунболд овогтой Мөнгөнтулгыг Шинэ Зеландын Nelson Aviation нисэхийн сургуулийн иргэний агаарын мэргэжлийн нисгэгчийн сургалтад, Баярсайхан овогтой Мандхайг АНУ-ын Калифорнийн Их сургуульд эдийн засгийн чиглэлээр, Жаргалсайхан овогтой Ариунсайханыг Япон улсын Ази Номхон Далайн Их сургуульд хүрээлэн буй орчны чиглэлээр, Бат-Эрдэнэ овогтой Батцэцэгийг АНУ-ын Antioch коллежид глобаль судлалын чиглэлээр, Энхтүвшин овогтой Баясгаланг АНУ-ын Денвер хотын Метрополитан коллежид мэдээлэл зүйн чиглэлээр, Хүрэлбаатар овогтой Оюунбилэгийг Хойд Вирджинийн Коммюнити коллежид бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2005-2006 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Гомбосүрэн овогтой Гэрэлмааг Англи улсын Лондонгийн Шинжлэх ухаан, Технологийн дээд сургуулийн магистрантурт мэдээллийн системийн удирдлагын чиглэлээр 1.5 жилийн хугацаагаар, Мөнхсайхан овогтой Батсайханыг АНУ-ын Хьюстон хотын Их сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр, Арслан овогтой Алтангэрэлийг Канад улсын Викториагийн Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Баяраа овогтой Одончимэгийг АНУ-ын Денвер хот дахь Колорадогийн Их сургуулийн магистрантурт эдийн засгийн чиглэлээр, Самбуу овогтой Даваадашийг АНУ-ын Монтерей Олон улс судлалын сургуулийн магистрантурт олон улсын бодлого судлалын чиглэлээр, Отгонбаяр овогтой Одончимэгийг Малайзын Inti College Sarawak сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Цэрэндаш овогтой Болормааг АНУ-ын Brigham Young Их сургуулийн

Сайдын 2005 оны 7 сарын 25 ны өдрийн 226 дугаар тушаал

3705484



магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр, Батжанцан овогтой Хишигжаргалыг Тайланд улсын Азийн Технологийн институтын магистрантурт хүнсний инженерийн чиглэлээр, Буян-Өлзий овогтой Пүрэвсүрэнг АНУ-ын Колорадогийн Техникийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Бохьшарга овогтой Жавзанхандыг ХБНГУ-ын Пассау Их сургуулийн магистрантурт эрх зүйн чиглэлээр, Базар овогтой Батхүүг Англи улсын Бирмингхам хотын их сургуулийн магистрантурт банк, санхүүгийн чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2005-2006 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

3. Сэрж овогтой Батцэцэгийг АНУ-ын Канзасын их сургуулийн докторантурт америк судлалын чиглэлээр, Доржсүрэн овогтой Анхтуяаг АНУ-ын Денвер хот дахь Колорадогийн Их сургуулийн докторантурт мэдээллийн системийн чиглэлээр, Гиваараднаа овогтой Тунгалагийг Австри улсын Венийн Их сургуулийн докторантурт хууль зүйн чиглэлээр, Чойжхүү овогтой Туулыг ХБНГУ-ын Дортмундын Их сургуулийн докторантурт материал судлалын чиглэлээр, Жамбалдорж овогтой Анхмааг ОХУ-ын Москвагийн Сэтгэцийн эмгэг судлалын эрдэм шинжилгээний институтын аспирантурт сексопатологийн чиглэлээр тус тус 3 жилийн хугацаагаар 2005-2006 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

4. Австрали улсын Бонд Их сургуулийн докторантурт суралцаж буй Бордох овогтой Оюунчимэг, ОХУ-ын Гадаад хэргийн яамны дэргэдэх Дипломатын академид суралцаж буй Лувсанчүлтэм овогтой Мягмарсүрэн, Даш овогтой Соёл-Эрдэнэ нарын суралцах хугацааг 1 жилээр, АНУ-ын Вирджинийн Их сургуулийн докторантурт суралцаж буй Батчулуун овогтой Алтанцэцэгийн суралцах хугацааг 2 жилээр тус тус сунгасугай.

5. ОХУ-ын Эрхүү хотын Эдийн засаг, эрх зүйн улсын их сургуулийн аспирантурт суралцаж буй Баттулга овогтой Батбямба, ОХУ-ын Улс түмний найрамдлын их сургуулийн аспирантурт суралцаж буй Паламдорж овогтой Ганчимэг, ОХУ-ын Москва хотын Хүнсний үйлдвэрийн их сургуулийн докторантурт суралцаж буй Дорж овогтой Цэцгээ нарын эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг тус тус зээлээр олгосугай.

6. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын Мэргэжлийн боловсролын хэлтэс /Д.Баяр/-т тус тус даалгасугай.



П.ЦАГААН